



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот


Азийн хүүхдийн спорт солилцооны наадмын ахлагчаар томилон ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2018 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс 27-ны өдрийг дуустал Япон улсын Токио хотноо зохион байгуулагдах Азийн хүүхдийн спорт солилцооны наадамд оролцох тамирчдын ахлагчаар тус хорооны Спортын хөгжлийн хэлтсийн дарга Сурмаажавын Саранцэцэгийг томилон ажиллуулсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд томилогдон ажилласан талаарх тайланг ажлын 7 хоногт багтаан тайлагнаж, судалж мэдсэн туршлагаа ажил үүрэгтээ нэвтрүүлж ажиллахыг Спортын хөгжлийн хэлтсийн дарга С.Саранцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД